



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2018

1-Р САР

Э-сонин

54-р дугаар





Зах зээлийн тойм

/2018.01.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

22

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

Хувьцаа

2,670,136,862.00

Засгийн газрын үнэт цаас /анхдагч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

20,124,921,830.00

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

7,200,000

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

4,824,206

Хувьцаа

4,620,535

Засгийн газрын үнэт цаас /анхдагч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

203,671

Компанийн бонд /анхдагч/


Компанийн бонд /хоёрдогч/

72


4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо

4,813


Зах зээлийн үнэлгээ



MSE ALL индекс



TOP-20 индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо

218

100% төрийн өмчит

19

Төрийн өмчийн оролцоотой

12

Хувийн өмчийн

187

I ангилал

9

II ангилал

40

III ангилал

169

Ангилалдаагүй

0

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо

58

Брокер, Дилер

50

Андеррайтер

23

Хөрөнгө оруулалтын зөвлөх

13



Үнэт цаасны зах зээл

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

/2018.01.31-ний байдлаар/

Сим бол	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Новел инвестмент ХХК	557,785	14,941,307,775.86	147,803	5,463,439,497.00	20,404,747,272.86
2	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	52,029	5,092,944,500.00	139,800	13,739,720,440.00	18,832,664,940.00
3	БиДиСек ХК	564,504	327,968,504.16	748,394	938,864,190.85	1,266,832,695.01
4	Голомт Капитал ХХК	618,049	502,381,826.66	522,967	713,747,674.33	1,216,129,500.99
5	Стандарт инвестмент ХХК	821,377	211,922,394.70	702,264	452,715,666.46	664,638,061.16
6	Бумбат-Алтай ХХК	275,887	372,833,418.80	323,695	231,052,844.45	603,886,263.25
7	Ти Ди Би Капитал ХХК	632,055	316,744,484.19	400,186	163,975,391.97	480,719,876.16
8	Гаули ХХК	140,876	266,299,973.40	43,109	57,829,929.00	324,129,902.40
9	Ард секьюритиз ХХК	296,476	178,705,788.30	270,929	134,067,498.90	312,773,287.20
10	Ард капитал групп ХХК	567,048	150,563,570.10	380,741	144,440,060.02	295,003,630.12
11	Мирэ Эссет Секьюритис Монгол ХХК	20,306	100,736,990.00	5,630	105,474,875.00	206,211,865.00
12	Гендекс ХХК	0	0.00	211,500	149,773,453.70	149,773,453.70
13	Блүмсбюри секьюритис ХХК	12,393	11,058,357.00	30,268	101,447,890.00	112,506,247.00
14	Лайфтайм инвестмент ХХК	12,722	93,453,629.48	1,364	3,750,796.00	97,204,425.48
15	Тэнгэр капитал ХХК	10,108	10,644,977.40	388,791	80,874,308.00	91,519,285.40
16	Монсек ХХК	44,066	49,272,732.32	264,194	41,447,839.30	90,720,571.62
17	Таван богд ХХК	64,572	50,459,487.00	5,038	22,578,376.00	73,037,863.00
18	Зэргэд ХХК	11,780	3,109,876.00	63,235	60,499,874.00	63,609,750.00
19	Алтан хоромсог ХХК	796	966,726.00	47,813	49,742,103.00	50,708,829.00
20	Санар ХХК	681	2,253,263.40	58,557	44,150,000.90	46,403,264.30

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2018.01.31-ний байдлаар/

№	Сим- бол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд	Доод	Хаалт	Өөрчлөлт /Нэгж/	Өөрчлөлт /%/
1	APU	АПУ	1,401,863	980,698,619.67	715.00	671.00	685.50	-31.20	-4.35
2	TTL	ТАВАН ТОЛГОЙ	58,817	587,190,280.00	10,950.00	8,800.00	10,410.00	1,500.00	16.84
3	GOV	ГОВЬ	14,229	355,791,500.00	29,000.00	23,500.00	24,660.00	1,400.00	6.02
4	JIV	ЖИНСТ-УВС	85,002	137,852,676.00	1,880.00	1,400.00	1,690.00	-168.00	-9.04
5	ITLS	АЙТҮҮЛС	597,379	99,549,556.70	195.00	140.00	158.00	-30.24	-16.06
6	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,933	61,267,090.00	22,000.00	19,500.00	21,000.00	-900.00	-4.11
7	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	88,101	54,698,179.20	680.00	595.00	640.16	87.66	15.87
8	MIK	МИК ХОЛДИНГ	4,283	47,627,680.00	12,000.00	9,850.00	11,490.00	1,040.00	9.95
9	TSK	ТАЛХ ЧИХЭР	1,816	45,004,600.00	29,000.00	23,760.00	25,300.00	-4,620.00	-15.44
10	JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	624,089	44,329,521.88	244.00	24.04	239.78	218.87	1,046.72
11	SUU	СҮҮ	157,163	39,875,971.33	262.00	249.00	253.89	-1.12	-0.44
12	SHG	ШАРЫН ГОЛ	14,881	38,849,906.00	3,163.00	2,112.00	3,100.00	801.00	34.84
13	RMC	РЕМИКОН	566,336	19,032,082.03	36.00	30.20	35.85	-0.83	-2.26
14	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	273,880	17,814,382.83	70.40	60.00	67.98	7.36	12.14
15	ATR	АТАР-ӨРГӨӨ	231	16,461,500.00	80,000.00	62,000.00	77,150.00	20,150.00	35.35
16	BDS	БИ ДИ СЕК	13,863	16,432,215.00	1,200.00	1,151.00	1,180.00	-31.00	-2.56
17	MRX	МЕРЕКС	447,611	13,054,197.00	35.00	27.00	32.10	2.10	7.00
18	ADU	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	2,864	11,550,512.00	4,033.00	4,033.00	4,033.00	526.00	15.00
19	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	16,758	8,298,038.00	515.00	461.00	515.00	7.95	1.57
20	BAN	БАГАНУУР	2,973	6,526,101.00	2,390.00	2,061.00	2,086.00	-214.00	-9.30



Үнэт цаасны зах зээл

Ханшийн өсөлттэй хувьцаа

/2018.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт / төгрөг/	Өөрчлөлт /%/
			2018-01-02	2018-01-31		
1	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	624,089	24.04	239.78	215.74	897.42
2	ГОНИР	208	285.00	460.00	175.00	61.40
3	ХҮННУ МЕНЕЖМЕНТ	6,005	23.21	35.29	12.08	52.05
4	ШАРЫН ГОЛ	14,881	2,299.00	3,100.00	801.00	34.84
5	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	3	251.20	332.21	81.01	32.25
6	Е-МОНИЕ	110	542.00	716.79	174.79	32.25
7	МОНГОЛ ШЕВРО	50	1,180.00	1,550.00	370.00	31.36
8	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	126	373.00	480.00	107.00	28.69
9	АТАР-ӨРГӨӨ	231	62,000.00	77,150.00	15,150.00	24.44
10	МОН НАБ	250	1,853.00	2,300.00	447.00	24.12
11	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	63	1,109.00	1,350.00	241.00	21.73
12	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	31,269	85.00	100.00	15.00	17.65
13	ТАВАН ТОЛГОЙ	58,817	8,940.00	10,410.00	1,470.00	16.44
14	НОЁТ ХАЙРХАН	90	1,000.00	1,150.00	150.00	15.00
15	СЭЛЭНГЭ СҮРЭГ	10	3,600.00	4,140.00	540.00	15.00
16	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	2,869	3,507.00	4,033.00	526.00	15.00
17	АЗЫК	87	1,955.00	2,248.00	293.00	14.99
18	ӨНДӨРХААН	5	9,775.00	11,240.00	1,465.00	14.99
19	ХӨХ ГАН	58,796	70.00	80.00	10.00	14.29
20	ОЛЛОО	659	58.00	66.00	8.00	13.79

Ханшийн бууралттай хувьцаа

/2018.01.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2018-01-02	2018-01-31		
1	МОГОЙН ГОЛ	210	11,440.00	8,000.00	-3,440.00	-30.07
2	УВС ЧАЦАРГАНА	110	750.00	546.00	-204.00	-27.20
3	МОННООС	132	3,799.00	3,000.00	-799.00	-21.03
4	МАТЕРИАЛИМПЕКС	513	10,900.00	9,000.00	-1,900.00	-17.43
5	ХИШИГ УУЛ	52	1,000.00	838.50	-161.50	-16.15
6	ТАЛХ ЧИХЭР	1,816	29,920.00	25,300.00	-4,620.00	-15.44
7	ИХ БАРИЛГА	12	5,000.00	4,251.00	-749.00	-14.98
8	МОНГОЛ НЭХМЭЛ	107	6,995.00	5,950.00	-1,045.00	-14.94
9	ЖУУЛЧИН ГОВЬ	14	4,131.00	3,515.00	-616.00	-14.91
10	СОР	840	1,139.00	970.00	-169.00	-14.84
11	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	1,194	469.00	400.00	-69.00	-14.71
12	АЙТҮҮЛС	597,379	185.06	158.00	-27.06	-14.62
13	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	14	93,120.00	80,000.00	-13,120.00	-14.09
14	БИНСЭ ХК	5	407.00	350.00	-57.00	-14.00
15	ХЭРЛЭН ХИВС	2,050	109.60	95.00	-14.60	-13.32



"АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР САНАЛ ГАРГАЛАА

"Улаанбаатар гурил" ХХК нь нэгдмэл сонирхолтой этгээдийн хамтаар "Атар өргөө" ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул "Компанийн тухай" хуулийн 57.1, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 22 дахь заалт, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, худалдан авах үйл ажиллагааны журам"-ын 3.1-д заасан үүргийн дагуу бусад хувьцаа эзэмшигч нарын өмчлөлд байгаа нийт 104,712 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 57,007 /сүүлийн 6-н сарын жигнэсэн дундаж ханш/ төгрөгөөр худалдан авах тендер санал гаргаж байна.

Санал болгож буй үнэ: 57,007 /

**Худалдан авах тоо
ширхэг:** 104,712 ширхэг

**Хувьцааг худалдан авах саналын эхлэх
хугацаа:** 2018 оны 1 сарын 15-ны өдөр

**Хувьцааг худалдан авах саналын дуусах
хугацаа:** 2018 оны 2 сарын 15-ны өдөр

**Хувьцааны худалдан авах төлбөрийн
хугацаа:** 2018 оны 2 сарын 15-ны өдөр

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо Чингисийн өргөн чөлөө, Таван богд ХХК-ийн төв байр

Дэлгэрэнгүй мэдээллийг 345225 утсаар авна уу.

МХБ-ИЙН "ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ"-Д ДАВХАР БҮРТГЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ТУСГАЖ, СЗХ-ГООР БАТЛАМЖЛУУЛАХААР ХҮРГҮҮЛЛЭЭ.

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга 2013 онд батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэлийг нэвтрүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулах нарийвчилсан журам батлагдаагүй байснаас гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд Монголын хөрөнгийн биржид

бүртгүүлэн үнэт цаасаа арилжих боломжгүй байсан билээ.

Иймд, үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах "Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам"-ыг СЗХ болон МХБ-ийн хамтарсан ажлын хэсгээс боловсруулж, СЗХ-ны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 223 тоот тогтоолоор баталсан. Тус журамтай нийцүүлэн, үнэт цаасны давхар бүртгэлийн үйл ажиллагааны зохицуулалтыг тусгасан, бүртгэлийн ажиллагааг олон улсын нийтлэг практиктай нийцүүлэн сайжруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгыг МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлан СЗХ-нд батламжлуулахаар хүргүүлээ.

МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн найруулгын онцлох өөрчлөлтүүдээс дурьдвал:

- Үнэт цаасны давхар бүртгэлийн ажиллагааг зохицуулах бүлэг нэмж, давхар бүртгүүлэх компаниудад тодорхой хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлэхээр тусгасан.
- Үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур, шаардлагыг шинэчлэн тогтоосон, уул уурхайн компаниудад тавигдах шалгуурыг нэмж оруулсан.
- Бүртгэлийн хураамжийн тооцооллыг зах зээлийн нийт үнэлгээнээс тооцохоор өөрчлөлт оруулсан. Компанийн сайн засаглалыг дэмжих үүднээс нэгдүгээр ангиллын компаниудын үнэт цаас бүртгүүлэх бүртгэлийн хураамж болон жилийн хураамжид хөнгөлөлт үзүүлэх заалтуудыг нэмсэн.
- Тогтвортой санхүүжилтийг дэмжих үүднээс тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үйл ажиллагаатай компаниудын бүртгэлийн хураамжийг хөнгөлөх зохицуулалтуудыг шинээр нэмж тусгасан.

МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" нь үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур, шаардлагыг тогтоох, үнэт цаас гаргагчийн байнгын үүргийг тодорхойлох зэргээр чухал ач холбогдолтой тул гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын үнэт цаасыг давхар бүртгэхийн тулд уг журам зайлшгүй шинэчлэгдэн СЗХ-гоор батламжлагдсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх шаардлагатай билээ.



МХБ-ИЙН “ҮНЭТ ЦААСНЫ ҮНИЙН ИНДЕКС ТООЦОХ ТУХАЙ ЖУРАМ”-ЫГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛЖ, СЗХ-ГООР БАТЛАМЖЛУУЛАХААР ХҮРГҮҮЛЛЭЭ.

МХБ нь үнэт цаасны үнийн индексийг 1995 оноос хойш тооцоолж байгаа бөгөөд МХБ-ийн ТУЗ-ийн 2017 оны 2017/09 тоот тогтоолоор “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай” журмын шинэчилсэн найруулгыг баталж, СЗХ-гоор батламжлуулахаар хүргүүлээ. МХБ-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох журам”-ын шинэчилсэн найруулгын онцлох өөрчлөлтүүдээс дурьдвал:

Компанийн үнэт цаасны олон нийтийн дунд чөлөөтэй арилжигдах тоо ширхгийг нарийвчлан тооцох

Үнэт цаасны олон нийтэд чөлөөтэй арилжигдах тоо ширхгийг үндэслэн индекс тооцох нь тооцооллыг нарийвчлан сайжруулдаг бөгөөд манай зах зээлийн хувьд зөвхөн төрийн эзэмшил дэх хувь хэмжээг индексийн тооцооллоос хасдаг байсан билээ. Индексийн тооцооллыг илүү нарийвчлалтай, зах зээлийн бодит хандлагад нийцүүлэхийн тулд нийт хувьцааны 5 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хөрөнгө оруулагчдын эзэмшил дэх хувь хэмжээг хасч тооцно.

ТОП20 индекс, I болон II ангиллын индексийг тус тус тооцох

МХБ-д бүртгэлтэй үнэт цаасыг бүртгэлийн шалгуураар I, II болон III ангилалд хуваадаг билээ. МХБ-д I болон II ангиллын үнэт цаасны индексийг нэвтрүүлснээр зах зээлийн чиг хандлагыг аль ангиллын компаниуд тогтоож байгааг харуулах төдийгүй индекст суурилсан бүтээгдэхүүн гаргах боломжийг бүрдүүлнэ.

MSE All индексийн тооцооллыг зогсоох

МХБ-д бүртгэлтэй зарим компаниуд, тухайлбал III ангиллын дийлэнх компаниуд нь идэвхтэй арилждаггүй бөгөөд арилжааны идэвх муутай компаниудыг оруулан индекс тооцох нь зах зээлийн чиг хандлагыг бодитоор харуулахгүй байх, тодруулбал өсөлт, бууралтын хэмжээг сааруулан харуулах тул MSE-All индексийн тооцооллыг зогсооно.

Индексийн сагсыг жилд нэг удаа тооцдог байх,

ТОП-20 индексийн багцыг хагас жил бүр шинэчлэн тогтоодог байсныг жилд нэг удаа шинэчилдэг болгож, олон улсын жишигтэй нийцүүлснээр индексийг дагаж хөрөнгө оруулалт хийх илүү тогтвортой хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлэх,

зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

МХБ-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай” журмын шинэчилсэн найруулгыг СЗХ-гоор батламжлуулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

МХБ-ИЙН ТУЗ-ӨӨС “АРИЛЖААНЫ ЖУРАМ”- Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЖ, СЗХ-ГООР БАТЛАМЖЛУУЛАХААР ХҮРГҮҮЛЛЭЭ

МХБ-ийн ТУЗ-ийн 2017 оны 2017/08 тоот тогтоолоор МХБ-ийн “Арилжааны журам”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг баталж, СЗХ-гоор батламжлуулахаар хүргүүлээ. МХБ-ийн “Арилжааны журам”-д оруулсан онцлох өөрчлөлтүүдээс дурьдвал:

Үнэт цаасны арилжааны хаалтын ханшийг сүүлийн нэг цагийн дунджаар тогтооно

Үнэт цаасны хаалтын ханш нь тухайн үнэт цаасны дараа өдрийн арилжааны ханшийн дээд, доод хязгаарыг тогтоох суурь нь болдог чухал ач холбогдолтой билээ. Үнэт цаасны арилжааны хаалтын ханшийг тухайн арилжааны өдөр хийгдсэн бүх арилжааны тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшаар тооцоолж байсныг үнэт цаасны сүүлийн нэг цагийн арилжааны тоо хэмжээгээр жигнэсэн дундаж ханшаар тооцож, хаалтын ханшийг илүү бодитой тогтоох боломжтой болно.

Үнэт цаасны багцын арилжааны ханшийг дээд хязгааргүй болгоно.

Үнэт цаасны багцын арилжааны ханш нь зах зээлтэйгээ уялдсан ханш байх шаардлагатай тул багцын арилжаанд өмнөх өдрийн хаалтын ханшаас 15%-иас илүүгүй хэлбэлзэлтэй байх хязгаар тогтоосон билээ. Гэвч үнэт цаас нь идэвхтэй арилждаггүй зарим компаниудын хувьд үнэт цаас бодит үнэлгээнээс бага байх тохиолдол их гардаг тул үнэт цаасны багцын арилжаанд ханшийн дээд хязгаар тавихгүй.

Үнэт цаасны захиалгын бусдад харагдах тоо ширхгийг тогтоох функцийг идэвхижүүлнэ

МХБ-ийн “Миллениум Ай Ти” арилжааны програмд арилжаанд оролцогч нь захиалгын бусдад харагдах тоо ширхгийг тогтоох боломжтой бөгөөд энэхүү функцийг идэвхижүүлснээр арилжаанд оролцогчид үнэт цаасны ханш, арилжааны идэвхид нөлөөлөхгүйгээр их хэмжээний үнэт цаас худалдах, худалдан авах боломжийг олгоно.



Захиалгын шинэ төрлүүдийг идэвхижүүлнэ

“Арилжааны журам”-ын нэмэлт, өөрчлөлтөөр захиалгын шинэ төрлүүдийг нэвтрүүлнэ. Тухайлбал, “Бүхэлд нь даруй биелэгдэх эсвэл цуцлагдах захиалга” /Fill or Kill/ нь шивэгдсэн даруйдаа бүрэн биелэх нөхцөлтэй ба биелээгүй тохиолдолд захиалгын сангаас цуцлагдана. “Минимумаас их дүнгээр биелэгдэх захиалга” /MinFill/ нь худалдах, худалдан авах хамгийн бага тоо хэмжээг зааж өгөх бөгөөд заасан хэмжээнээс бага хэмжээгээр биелэгдэхгүй байх нөхцөлтэй захиалга юм. Эдгээр шинэ боломжууд нь арилжаанд оролцогчийг үнэт цаасны захиалгаа илүү нарийн өгөгдөлтэй оруулах, арилжааны илүү таатай орчинд ажиллах боломжийг олгоно.

МХБ-ийн “Арилжааны журам”-ын нэмэлт, өөрчлөлтүүдийг СЗХ-ноос батламжилснаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖИЛИЙН ХУРААМЖИЙГ ЗАРИМ КОМПАНИУДАД ХӨНГӨЛЛӨӨ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83.1 зүйл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 8.10.11 заалт, Гишүүнчлэлийн журмын 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн гаргасан Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын А/4 тоот тушаалын дагуу 2017 онд МХБ-ийн нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас дээш хувьтай тэнцэх хэмжээний гүйлгээг хийсэн нэр бүхий дараах 6 гишүүн үнэт цаасны компанийг 2018 оны гишүүнчлэлийн жилийн хураамжаас тус бүр 10 хувийн хөнгөлөлт эдлүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

1. “Новел Инвестмент ҮЦК” ХХК
2. “Би Ди Сек ҮЦК” ХК
3. “Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК” ХХК
4. “Голомт Капитал ҮЦК” ХХК
5. “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК
6. “Тэнгэр Капитал ҮЦК” ХХ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Чингис Хааны талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN